



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/45/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2024 оны 02 дугаар сар 24

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com
Аудитор: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Албан шаардлага	17
5.2 Зөвлөмж	17
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



Г]
ӨЛЗИЙТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ө.ХАШБИЛЭГ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23. № 2/24

танай _____-ны № _____-т

Г]

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 1,782,182.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,650,509,7 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 4,696.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 137,587.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

5020262

Аудитаар Аймгийн ИТХ-ын даргын "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 2023 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар захирамжаар Өлзийт сумын ЗДТгазраас балансаас балансад шилжүүлсэн 11,320.5 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй, газар эзэмших эрхийн зөрчилтэй байгаа нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй байгаа нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 16 зорилтын 148 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95,3 хувьтай тайлагнасныг 85.2 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	319,003,162.43	374,638,683.36
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	113,130,329.50	137,587,954.66
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	113,130,329.50	137,587,954.66
31210	Төгрөг	113,130,329.50	137,587,954.66
31211	Төрийн сангийн харилцах	113,130,329.50	137,587,954.66
33	АВЛАГА	29,204,000.00	2,418,205.77
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	2,418,205.77
33500	Бусад авлага	29,204,000.00	0
33510	Байгууллагаас авах авлага	29,204,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	176,668,832.93	171,834,256.93
35100	Түүхий эд материал	115,044,154.80	104,403,727.80
35110	Тусгай зориулалттай материал	114,729,954.80	104,178,527.80
35130	Эм боох материал	314,200.00	225,200.00
35400	Хангамжийн материал	61,624,678.13	67,430,529.13
35410	Бичиг хэргийн материал	2,142,100.00	2,356,000.00
35420	Аж ахуйн материал	5,102,954.00	6,166,954.00
35440	Түлш, шатах тослох материал	600,000.00	750,000.00
35450	Барилгын засварын материал	2,715,000.00	64,168,266.00
35460	Хүнсний материал	472,880.00	0
35470	Бусад хангамжийн материал	50,591,744.13	56,787,575.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,253,080,655.03	3,113,748,394.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,253,080,655.03	3,113,748,394.35
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	3,217,774,210.55	3,079,875,283.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,358,023,120.00	3,358,023,120.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-463,043,316.94	-603,196,186.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,783,333.44	6,283,333.44
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,284,259.30	-6,212,037.10
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	277,372,572.40	344,221,877.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-121,892,599.05	-159,643,232.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	278,378,208.32	283,673,208.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-138,528,078.32	-170,240,030.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,965,230.00	26,965,230.00
39300	Биет бус хөрөнгө	35,306,444.48	33,873,111.20
39301	Програм хангамж	4,600,000.00	4,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,255,555.52	-2,688,888.80
39303	Бусад биет бус хөрөнгө	31,962,000.00	31,962,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,572,083,817.46	3,488,387,077.71
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,572,083,817.46	3,488,387,077.71
51	Засгийн газрын хувь оролцоо	3,572,083,817.46	3,488,387,077.71
51100	Засгийн газрын оруулсан капитал	821,578,958.90	821,578,958.90
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	821,578,958.90	821,578,958.90
51200	Хуримтлагдсан үр дүн	1,887,064,054.44	1,803,367,314.69
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,680,719,763.02	1,887,064,054.44
51220	Тайлант үеийн үр дүн	3,567,783,817.46	-83,696,739.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	863,440,804.12	863,440,804.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,572,083,817.46	3,488,387,077.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,562,333,854.22	1,756,712,578.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	119,613,654.22	80,347,278.00
120	Нийтлэг татварын бус орлого	119,613,654.22	80,347,278.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,632,200.00	3,298,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,632,200.00	3,098,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	112,694,359.50	5,425,105.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,287,094.72	71,623,473.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,442,720,200.00	1,676,365,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,175,714,500.00	1,420,443,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,175,714,500.00	1,420,443,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	266,505,700.00	255,921,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	266,505,700.00	255,921,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,491,646,806.17	1,840,409,317.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,491,646,806.17	1,840,409,317.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,409,197,376.76	1,763,825,134.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	777,957,065.00	1,017,134,123.02
210101	Үндсэн цалин	563,061,459.00	727,771,211.03
210102	Нэмэгдэл	160,379,268.00	244,344,272.49
210104	Урамшуулал	22,268,600.00	45,018,639.50
210105	Гэрээт ажлын хөлс	32,247,738.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,465,187.00	126,334,089.56
210201	Тэтгэврийн даатгал	66,580,952.76	86,001,246.38
210202	Тэтгэмжийн даатгал	7,834,296.85	9,227,617.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,253,997.58	8,334,674.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,521,424.21	1,827,015.72
210205	Эрүүл мэндийн даатгал	15,274,515.60	20,943,534.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,285,378.59	246,081,972.41
210301	Гэрэл, цахилгаан	14,137,179.59	17,721,992.41
210302	Түлш, халаалт	203,148,199.00	228,359,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,882,808.50	25,518,072.79
210401	Бичиг хэрэг	6,638,360.00	8,794,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	475,271.50	704,130.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,202,700.00	0
210408	Бараа материал акалсны зардал	366,477.00	15,659,842.00
2105	Нормативт зардал	73,837,993.00	85,200,020.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,690.00	0
210502	Хоол, хүнс	73,718,303.00	85,200,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,719,400.00	6,413,000.00
210604	Урсгал засвар	2,719,400.00	6,413,000.00
2107	Томилолт, зочны зардал	864,500.00	0
210702	Дотоод албан томилолт	864,500.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,694,500.00	9,280,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,216,700.00	1,250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,477,800.00	8,030,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	215,490,544.67	247,862,956.68

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,692,296.00	24,377,341.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,408,210.00	12,009,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	188,390,038.67	211,476,565.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,449,429.41	76,584,183.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,054,320.00	71,887,555.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,811,500.00	51,037,990.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,242,820.00	20,849,565.70
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,395,109.41	4,696,627.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,395,109.41	4,696,627.59
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	70,687,048.05	-83,696,739.75
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	70,687,048.05	-83,696,739.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,449,652,400.00	1,679,664,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,932,200.00	3,298,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,932,200.00	3,298,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,632,200.00	3,298,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,632,200.00	3,098,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	200,000.00
120009	Бусад орлого	4,300,000.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,442,720,200.00	1,676,365,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,175,714,500.00	1,420,443,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,175,714,500.00	1,420,443,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	266,505,700.00	255,921,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	266,505,700.00	255,921,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,328,222,470.50	1,617,691,174.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,245,771,461.09	1,541,594,631.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	777,957,065.00	1,015,138,500.95
210101	Үндсэн цалин	563,061,459.00	722,049,668.47
210102	Нэмэгдэл	160,379,268.00	248,070,192.98
210104	Урамшуулал	22,268,600.00	45,018,639.50
210105	Гэрээт ажлын хөлс	32,247,738.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,465,187.00	130,747,917.40
210201	Тэтгэврийн даатгал	66,580,952.76	89,027,266.64
210202	Тэтгэмжийн даатгал	7,834,296.85	10,615,425.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,253,997.58	8,334,674.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,521,424.21	1,827,015.72
210205	Эрүүл мэндийн даатгал	15,274,515.60	20,943,534.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	213,885,378.59	246,231,972.41
210301	Гэрэл, цахилгаан	14,137,179.59	17,721,992.41
210302	Түлш, халаалт	199,748,199.00	228,509,980.00
2105	Нормативт зардал	73,119,283.00	85,214,780.00
210502	Хоол, хүнс	73,119,283.00	85,214,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,946,500.00	4,993,000.00

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,946,500.00	4,993,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,429,100.00	9,280,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,105,700.00	1,250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,323,400.00	8,030,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,968,947.50	49,987,560.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,496,777.50	37,978,510.79
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,472,170.00	12,009,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,451,009.41	76,096,543.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,055,900.00	71,399,915.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,811,500.00	50,550,350.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,244,400.00	20,849,565.70
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,395,109.41	4,696,627.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,395,109.41	4,696,627.59
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	121,429,929.50	61,972,825.16
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,299,600.00	37,515,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,299,600.00	37,515,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,299,600.00	37,515,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,299,600.00	37,515,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-8,299,600.00	-37,515,200.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	113,130,329.50	24,457,625.16
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	113,130,329.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	113,130,329.50	137,587,954.66

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	821,578,958.90	863,440,804.12	-1,680,719,763.02	4,300,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	-1,680,719,763.02	4,300,000.00
4	Тайлант үеийн үр дүн	0	0	3,567,783,817.46	3,567,783,817.46
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	1,887,064,054.44	3,572,083,817.46
6	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	1,887,064,054.44	3,572,083,817.46
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	1,887,064,054.44	3,572,083,817.46
8	Тайлант үеийн үр дүн	0	0	-83,696,739.75	-83,696,739.75
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	1,803,367,314.69	3,488,387,077.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,792,182,400.00	1,650,509,747.25	141,672,652.75	92.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,792,182,400.00	1,650,509,747.25	141,672,652.75	92.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,712,289,000.00	1,579,109,831.55	133,179,168.45	92.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,122,479,000.00	1,015,138,500.95	107,340,499.05	90.4
210101	Үндсэн цалин	768,649,000.00	722,049,668.47	46,599,331.53	93.9
210102	Нэмэгдэл	298,575,600.00	248,070,192.98	50,505,407.02	83.1
210104	Урамшуулал	55,254,400.00	45,018,639.50	10,235,760.50	81.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,309,400.00	130,747,917.40	9,561,482.60	93.2
210201	Тэтгэврийн даатгал	95,410,400.00	89,027,266.64	6,383,133.36	93.3
210202	Тэтгэмжийн даатгал	11,224,700.00	10,615,425.27	609,274.73	94.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,979,800.00	8,334,674.80	645,125.20	92.8
210204	Ажилгүйдлийн даатгал	2,244,900.00	1,827,015.72	417,884.28	81.4
210205	Эрүүл мэндийн даатгал	22,449,600.00	20,943,534.97	1,506,065.03	93.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,921,600.00	246,231,972.41	4,689,627.59	98.1
210301	Гэрэл, цахилгаан	18,281,800.00	17,721,992.41	559,807.59	96.9
210302	Түлш, халаалт	228,539,800.00	228,509,980.00	29,820.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,100,000.00	0	4,100,000.00	0.0
2105	Нормативт зардал	95,185,800.00	85,214,780.00	9,971,020.00	89.5
210502	Хоол, хүнс	95,185,800.00	85,214,780.00	9,971,020.00	89.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,993,000.00	7,000.00	99.9
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,993,000.00	7,000.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,664,400.00	9,280,900.00	1,383,500.00	87.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,633,500.00	1,250,000.00	1,383,500.00	47.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,030,900.00	8,030,900.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,728,800.00	87,502,760.79	226,039.21	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,682,500.00	75,493,710.79	188,789.21	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,046,300.00	12,009,050.00	37,250.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,893,400.00	71,399,915.70	8,493,484.30	89.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,893,400.00	71,399,915.70	8,493,484.30	89.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,013,100.00	50,550,350.00	8,462,750.00	85.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,880,300.00	20,849,565.70	30,734.30	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,792,182,400.00	1,674,967,372.41	17,564,527.59	99.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,420,443,700.00	1,420,443,700.00		100
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,420,443,700.00	1,420,443,700.00		100
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	255,921,600.00	251,224,972.41	4,696,627.59	98.2
320001	Орон нутгийн төсвөөс	255,921,600.00	251,224,972.41	4,696,627.59	98.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,687,000.00	3,298,700.00	-611,700.00	122.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,607,000.00	3,098,700.00	-491,700.00	118.86
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000.00	200,000.00	-120,000.00	250.0

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	113,130,100.00	0	113,130,100.00	#DIV/0!
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	113,130,329.50	113,130,329.50	#DIV/0!
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	137,587,954.66	137,587,954.66	#DIV/0!
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0	0.00	#DIV/0!
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	65	100.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	100.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	32	32	100.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	32	32	100.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	500	500		100
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	500	500		100
630001	Төрийн өмчит ЕБС	500	500		100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба бүтэц зохион байгуулалттай 56 орон тоотой, 508 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 83,696.7 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	113,130,3	137,587,9	24,457,6
Авлага	29,204,0	2,418,2	26,785,8
Бараа материал	176,668,8	234,632,5	57,963,7
Үндсэн хөрөнгө	4,007,084,4	4,055,728,7	48,644,3
Хуримтлагдсан элэгдэл	-754,003,8	-941,980,3	-187,976,5
Нийт хөрөнгө	3,572,083,8	3,488,387,0	-83,696,7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,572,083,8	3,488,387,0	-83,696,7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,572,083,8	3,488,387,0	-83,696,7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Өлзийт сумын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь бараа материал, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 113,130.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 137,587.9 мянган төгрөгийн өмнөх оноос 24,457.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 178,166.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 71,623.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 174,496.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж Захирлын тушаалаар 17,329.0 мянган төгрөгийн бараа материал актлаж бараа материалын үлдэгдэл 57,963.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Аймгийн ИТХ-ын даргын “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 2023 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар захирамжаар Өлзийт сумын ЗДТГазраас бараа материалын нөөц хөрөнгөнд бүртгэлтэй сургууль, дотуур байрны ариун цэврийн өрөө гэсэн зарлагын баримтаар 62,798.2 мянган төгрөгийн орлогыг бараа материалын авсантай холбоотой байна.

Тайлант онд авлага 29,204.0 мянган төгрөгөөр буурч НДШимтгэл төлөлтийн 2,418,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 37,515.2 мянга, 2022 оны авлагаар 29,204.0 мянга, Боловсролын ерөнхий газраас 1,246.3 мянган төгрөг, Өлзийт сумын ЗДТГазраас 4,179.0 мянган төгрөгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, Тээврийн хэрэгсэлээс 23,500.0 мянган төгрөгийн автомашиныг орон нутгийн өмчийн газарт шилжүүлж 48,644.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 83,696.7 мянган төгрөгөөр буурч, 3,488,387.0 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 83,696.7 мянган төгрөгөөр буурч 3,488,387.0 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,544,741.3 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 1,544,741.4 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 458,274.9 мянган төгрөгөөр буурч 1,086,466.4 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1420,443.7 мянган төгрөг болгож 333,977.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан

1,420,443.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 113,130.1 мянга, үйл ажиллагааны орлогоос 2,687.0 мянга, орон нутгийн төсвөөс 255,921.6 мянган төгрөг нийт 1,732,182.4 мянган төгрөгийн эх үүсвэртэй гүйцэтгэлээр 1,650,509.7 мянган төгрөгийг зарцуулж, 137,587.9 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 255,921.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 98.2 хувь буюу 251,224.9 мянган төгрөгийг зарцуулж, 4,696.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	3,212.4	3,159.7	52.7	94.3
2	80312 Сургалт семинар	1,884.8	1,884.5	0.3	99
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	3,264.4	3,250.0	14.4	95.5
4	81801 Үдийн цай хөтөлбөр	59,013.1	50,550.5	8,462.7	80.1
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	140,990.1	125,532.4	15,457.7	87.8
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	34,329.3	34,329.3	0.00	100.0
7	81823 Боловсролын байгууллагын багш	7,773.2	7,764.6	8.6	90.9
8	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	12,880.0	12,877.0	3.0	99.0
9	81834 Боловсролын стандарт, сургалтын	1,048,949.1	946,181.1	102,768.0	86.7
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	221,250.9	212,425.8	8,825.1	87.3
11	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	80.0	80.0	0.00	100.0
11	81848 Сурах бичгийн түрээс	2,633.5	1,250.0	1,383.5	87.0
12	80112 Нийтлэг үйлчилгээ	255,921.6	251,225.0	4,696.6	98.2
ДҮН		1,792,182.4	1,650,509.7	141,672.6	92.1

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 59,013.0 мянган төгрөгийн батлагдсан төсөвт 2 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан 2 багц болгон нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр Баян баялаг өргөө ХХК, Гэгээн их ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 50,550.3 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 95,185.8 мянган төгрөг батлагдаж төсөвт 2 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан 2 багц болгон нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр

Софтвишн ХХК, Гэгээн их ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 85,214.8 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 25,172.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн газрын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ө.Хашбилэг, 2 дугаар гарын үсгийг 2023 оны 1 дүгээр сараас 2 сар хүртэл нягтлан бодогч Б.Мөнхтогтох, 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс нягтлан бодогч Б.Жамбалдорж нар зурж, нярваар Ш.Бумцэнд нар ажиллажээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үеийн материалаг байдлыг 2023 оны 3-р улирлын байдлаар тогтоосон тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 1870,016.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 28,050.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 21,037.6 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,665,343.3 мянган төгрөгийн 23 гүйлгээ, зарлагын 304,792.6 мянган төгрөгийн 18 гүйлгээ, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б. Нарангэрэл гүйцэтгэж, 6,290.3 мянган төгрөгийн албан шаардлага, менежментийн захидлаар 6,701.9 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1331.3	2	1331.3	100
Албан шаардлага					
Зөвлөмж	2	29204.0	2	29204.0	100.0
Нийт дүн	4	30,535.3	4	30,535.3	100.0

Эх сурвалж: Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023.06.06-ны өдрийн 69 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.06.06-ны өдөр 69 дугаар албан бичгээр ирүүлж бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 29,603,9 мянган төгрөгийн алдаа илэрсэнийг аудитын явцад залруулав. Үүнд:

-Авлагаар авсан 29,204.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогын дансаар авч авлагыг бусад бараа үйлчилгээний зардалд бичиж хаасан.

-Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн авлагыг 399,9 мянган төгрөгөөр дутуу тусгасан.

Аудитаар нийт 11,320.5 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэнд 2 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудлаар

1.Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын даргын "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай "2023 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар захирамжаар Өлзийт сумын ЗДТгазраас балансаас балансад шилжүүлсэн 11,320,5 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй, тооллогын бүртгэлээр баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.6. эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;гэсэн заалтыг зөрчиж Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийг орлогод авч зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудлаар

2.Илрүүлэлт: Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 14,170 м2 талбай бүхий газрыг 2012 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/07 дугаар, 1430м2 талбай бүхий газрыг 2009 оны 11 сарын 18 өдрийн А/19 дүгээр , 2405 м2 талбай бүхий газрыг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/168 дугаар

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

захирамжаар олгож, газрын нэгдсэн санд бүртгэлтэй байхад байгууллагын санхүүгийн тайланд 15981 м2-аар бүртгэсэн, газрын хэмжээ 2024 м2 зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүүгийн тайланд 2024 м2 газрыг бүртгэн зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын даргын Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай 2023 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар захирамжын дагуу Өлзийт сумын ЗДТГазраас 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар зарлагын баримтаар сургууль дотуур байрны ариун цэврийн өрөө гэсэн баримттай 62,798,2 мянган төгрөгийн орлогын задаргаа байхгүй тул барилга засварын материалын дансанд орлого хөрөнгийн задаргааг нэр төрлөөр хийж холбогдох дансанд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.гэсэн заалт, УСНББОУС-17-г зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг захирамжийн дагуу барилга засварын материалын данснаас үндсэн хөрөнгөнд орлогод авч тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү..

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгаагүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлантай холбоотой алдаа										
Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн авлагыг 399,9 мянган төгрөгөөр дутуу тусгасан.	1	399,9	1	399,9			1	399,9	0	0
Авлагаар авсан 29,204.0 мянган төгрөгийн үндсэн ххөрөнгийг үнэ төлбөргүй орлогын дансаар авч авлагыг бусад бараа үйлчилгээний зардалд бичиж хаасан.	1	29204.0			1	29204.0	1	29204.0		
Нийт дүн	2	29603,9	1	399,9	1	29204.0	1	29603,9		

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Аймгийн ИТХ-ын даргын "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай "2023 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар захирамжаар Өлзийт сумын ЗДТгазраас балансаас балансад шилжүүлсэн 11,320,500 төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй, тооллогын бүртгэлээр баталгаажуулаагүй	1	11320.5			1	11320.5		
Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 14,170 м2 талбай бүхий газрыг 2012 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/07 дугаар, 1430м2 талбай бүхий газрыг 2009 оны 11 сарын 18 өдрийн А/19 дүгээр , 2405 м2 талбай бүхий газрыг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/168 дугаар захирамжаар олгож, газрын нэгдсэн санд бүртгэлтэй байхад байгууллагын санхүүгийн тайланд 15981 м2-аар бүртгэсэн, газрын хэмжээ 2024 м2 зөрүүтэй.	1				1			
Нийт дүн	2	11320.5			2	11320.5		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 100/14210513/БНА/2024
145/НА-СМА-ТМЗ.

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 14,170 м2 талбай бүхий газрыг 2012 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/07 дугаар, 1430м2 талбай бүхий газрыг 2009 оны 11 сарын 18 өдрийн А/19 дүгээр, 2405 м2 талбай бүхий газрыг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/168 дугаар захирамжаар нийт 18005 м2 газар олгосоньг газрын нэгдсэн санд бүртгэлтэй тулган шалгахад байгууллагын санхүүгийн тайланд 15981 м2-аар бүртгэсэн, газрын хэмжээ 2024 м2 зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад

5040195

нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлээс зөрүүтэй 2024 м2 газрыг бүртгэн зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Хашбилэг нягтлан бодогч Б.Жамбалдорж нарт даалгав^{2,3}.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:

О. МАНДАХ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 2 сарын 23 өдөр

Дугаар 104/14210573/БНА/2024
/45/НА-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргын "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай "2023 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар захирамжаар Өлзийт сумын ЗДТгазраас балансаас балансад шилжүүлсэн 11,320,500 төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй, тооллогын бүртгэлээр баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.6. эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтыг зөрчиж Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.2 дахь "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040207

